# МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХЭД

2024 оны 09 сарын 05 өдөр Улаанбаатар хот

*Хяналтын шатны журмаар гомдол гаргах тухай*

**Гомдол гаргасан тал:** Нэхэмжлэгч тал

**Гомдлын шаардлага:** Дархан-Уул аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 4 дүгээр сары 09-ний өдрийн 0010 дугаартай шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн 0476 дугаар магадлалыг тус тус хүчингүй болгуулж, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангуулах тухай.

**Гомдлын үндэслэл:**

1. Давж заалдах шатны шүүх "... маргаан бүхий 8658 м.кв газрын эзэмших эрх нэхэмжлэгч Б.Пүрэвсүрэнд Газрын тухай хуулиар тогтоосон нөхцөл, журмын үүссэн гэх нөхцөл байдал тогтоогдохгүй байгаа учраас "газар эзэмших эрх" зөрчигдсөн гэж үзэхгүй" гэж дүгнэсэн.

2. "Дархан мах экспо" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 1999 оны 12 дугаар сарын 21-ий өдрийн хурлын тогтоолоор "тус компанийн 1993 онд 40 мянган төгрөгөөр худлдсан модон барилгыг ТӨХ-ны 1997 оны 38 тоот тогтоолоор буцааж авсныг худалдан авагчийн гаргасан гомдол болон бусад баримтуудыг үндэслэн хэлэлцээд ...40 мянган төгрөгийн өртөг бүхий модон барилгын төлбөр хийсэн баримтыг үндэслэн иргэн Ч.Пүрэвдоржид буцаан олгож" гэж шийдвэрлэсэн. Уг барилгыг Б.Пүрэвдорж Б.Пүрэвсүрэнтэй 2000 оны 02 дугаар сарын 17-ны өдөр Худалдах, худалдан авах гэрээ байгуулж 3 сая төгрөгөөр худалдсан, мөн Дархан-Уул аймгийн Засаг даргаас нэхэмжлэгч Б.Пүрэвсүрэнгийн нэр дээр 8568 м.кв газрын 20 жилийн хугацаааатайгаар эзэмшүүлэх 08090053 дугаар гэрчилгээг 1999 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр олгосон, газар болон газар дээрх модон барилгын тухайн үеийн болон түүнчлэн нэхэмжлэгч маргаж буй газар дээр өлөнгийн цехийн үйл ажиллагаа явуулж байсан талаарх фото зураг, шүүхээс газар дээр очиж хийсэн үзлэгийн тэмдэглэл, фото зургуудаар нэхэмжлэгчид газар эзэмших хуулийн дагуу үүссэн гэдэг нь нотлогдоно. Нэхэмжлэгчид газар эзэмших олгосон Засаг даргын захирамж олдохгүй байгаа нь нэхэмжлэгчийн буруу биш гэж үзэж байна.

3. Нөгөө талаас тэгш хандах, шударга байх зармын үүднээс авч үзвэл хэрэгт авагдсан баримтаас үзэхэд Дархан-Уул аймгийн Дархан сумын Засаг даргын 2003 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 118 дугаар захирамжаар "Дархан мах-Экспо" ХХК-д 3-р багт 88,000 м.кв газрын эзэмших эрхийг олгосон байдаг. Гэтэл иймхүү захирамж гарахаа өмнө буюу 2002 оны 3 дугаар сарын 31-ний өдөр Засаг даргын захирамж байхгүй байхд "Дархан мах-Экспо" ХХК-тай газар эзэмшүүлэх гэрээ байгуулж байсан, тус компанид газар эзэмших эрхийн гэрчилгээ олгогдож байгаагүй, тус компани 1997-2009 оны хугацаанд газрын төлбөрөө төлж байгаагүй[1], газраа кадастрын улсын бүртгэлд бүртгүүлж байгаагүй байдаг. Харин Дархан-Уул аймгийн Засаг даргын 2010 оны 8 дугаар сарын 06-

---

[1] Газрын алба тус компаниас газрын төлбөрт 20,485,873 төгрөг гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргаж байсан, Чингис хаан банкинд гаргаж огсон тодорхойлолтоор 1997-2009 оны хүртэл газрын төлбөрт 30.694.000 төгрөгийн өртэй гэсэн баримт хэрэгт авагдсан.

ны өдрийн 311 дүгээр захирамжаар газар эзэмших эрхийг “Русмяспром” ХХК[2] руу шилжүүлж, тус компани захирамж гарснаас хойш 5 хоногийн дараа буюу 2010 оны 8 дугаар сарын 11-ний өдөр гарсан 0174684 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээгээ авч, тус газрыг анх удаагаа кадастрын улсын бүртгэлийн нэгж талбарын 080100477 дугаарт бүртгүүлсэн. Ингэхдээ газрын хэмжээг 88,000 м.кв-аас 98,469 м.кв болж нэмэгдүүлж гэрчилгээндээ бичүүлсэн байдаг.

4. Давж заалдах шатны шүүх “... нэхэмжлэгчээс захиргааны хэргийн шүүхэд хандаж хүчингүй болгуулх, илт хууль бус болохыг тогтоолгохоор маргаж буй захиргааны акт нь /а/ хууль зөрчсөн байхын зэрэгцээ /б/ түүний эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдсан бол шүүх тухай захиргааны акты хүчингүй болгох боломжтой” гэж дүгнэжээ.

5. Хүчингүй болгуулах нэхэмжлэлийн тухайд дээрх нөхцөлийг шаардах ч харин “захиргааны актыг илт хууль бус болохыг тогтоолгох” нэхэмжлэлийн тухайд шууд ингэж дүгнэх нь учир дутагдалтай гэж үзэж байна. Учир нь нэгдүгээрт, хууль тогтоогч Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106.3.1, 106.3.2 дахь заалтын томьёоллыг өөр өөрөөр хийсэн байгаа нь санамсаргүй хэрэг биш болов уу. Шүүх тус хуулийн 106.3.1-д заснаар “захиргааны акт хууль зөрчсөн, түүний улмаас нэхэмжлэгчгийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн нь тогтоогдсон бол түүнийг хүчингүй болгох, харин 106.3.2-т зааснаар захиргааны илт хууль бус бол түүнийг “илт хууль бус болохыг тогтоох” шийдвэрийг гаргахаар байна. Хоёрдугааарт, энэ нь захиргааны актын эрх зүйн зөрчил буюу алдааны үр дагавартай холбогдоно. Захиргааны ерөнхий хуулийн 47.1-д заасан захиргааны акт нь анхнаасаа хүчин төгөлдөр бус буюу гарсан цагаасаа эрх зүйн үйлчлэлгүй байх бөгөөд ийм учраас түүний эсрэг нэхэмжлэл гаргасан ч, гаргаагүй ч хүчингүй байна. Ийм учраас хууль тогтоогч хуулийн 106.3.2 дахь заалтын томьёоллыг 106.3.1 дэх заалтын томьёололтой ижил бичээгүй гэж үзэх үндэслэлтэй.

6. Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 234 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 0445 дугаар магадлал, Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2018 оны 10 дугаар сарын 29-ний өдөр 413 дугаар тогтоолоор тус тус дүгнэснээр “газар эзэмших эрх олгосон Засаг даргын захирамж гараагүй байхад газрын алба нэгж талбарын дугаар үүсгэж, газрын мэдээллийн санд бүртгэх замааар бусдад газар олгосныг “илт хууль бус захиргааны акт” гэсэн байдаг. Тэгвэл энэ хэрэгт авагдсан нотлох баримтаар Дархан-Уул аймгийн Засаг даргын 2010 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн 311 дүгээр захирамжаар газар эзэмших эрхийг “Русмяспром” ХХК-д шилжүүлсэн. Уг захирамжийн хавсралтаас үзэхэд газрын хэмжээ 88,000 м.кв буюу өөрчлөгдөөгүй байна. Харин уг захирамж гарснаас хойш 5 хоногийн дараа буюу 2010 оны 8 дугаар сарын 11-ний өдөр гарсан 0174684 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээгээр газрын хэмжээ 98,469 м.кв болж нэмэгдэн, нэгж талбарын 080100477 дугаар олгогдсон нь хөтөлбөргүйгээр тогтоогдсон буюу “илт хууль бус захиргааны акт” гарсан байдаг.

7. Гэтэл давж зааалдах шатны шүүх нэхэмжлэжгчийн эрх зөрчигдөөгүй гэдэг үндэслэлээр “илт хууль бус захиргааны акт”-ын дагуу гуравдагч этгээд “Дархан мах корпораци” ХХК засаг газар эзэмших эрх хэрэгжүүлэхийг зөвшөөрч байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан төрийн үйл ажиллагааны “хууль дээдлэх” зарчмыг баримтлах үзэл санаа, Захиргааны ерөнхий хуулийн 4.1.1-д заасан “хуульд үндэслэх” зарчим, Газрын тухай хуулийн 4.1.3-т заасан “газар өмчлөх,

[2] “Русмяспром” ХХК нь сүүлд 2016 оны 12 дугаар сарын 20-ны өдөр нэрээ “Дархан мах корпораци” ХХК болгож өөрчилсөн талаарх баримт хэрэгт авагдсан.

эзэмших, ашиглахад шударга ёс, тэгш байдлыг хангах” зарчмыг алдагдуулсан, илт хууль бус захиргааны акт гарсан цагаасаа эрх зүйн үйлчлэлгүй байх, түүний эсрэг нэхэмжлэл гаргасан ч, гаргаагүй ч хүчингүй байх захиргааны эрх зүйн онол, зарчимтай нийцэхгүй шийдвэрийг гаргасан гэж үзэж байна. Анхан болон давж заалдах шатны шүүх ийнхүү хариуцагчийн хууль зөрчсөн (түүний дотор илт хууль бус, ноцотойгоор хуулийг зөрчсөн) үйлдлийг “зөвтгөснөөр” (“буруутгах үндэслэлгүй байна” гэж дүгнэснээр) захиргааны хууль бус үйл ажиллагааг улам бүр дэвреэх үндэслэл болж болохыг бодолцсонгүй, анхаарсангүй.

Иймд Дархан-Уул аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 4 дүгээр сары 09-ний өдрийн 0010 дугаартай шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн 0476 дугаар магадлалыг тус тус хүчингүй болгож, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж өгнө үү.

Гомдол гаргасан,

НЭХЭМЛЭГЧИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ П.БАТТУЛГА

НЭХЭМЖЛЭГЧИЙН ӨМГӨӨЛӨГЧ Б.СОДБОЛД